



**ХӨВСГӨЛ
АЛТАНДУУЛГА**
ХУВЬЦААТ КОМПАНИ

2025

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

Хөвсгөл Алтандуулга ХК-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал:
2025 оны 04-р сарын 25-ны өдрийн 11 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг,
Компанийн хурлын танхимд болно.



Сайн Сайхны Төлөө!

Бүтээв...

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН
2025 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

№	Танилцуулах асуудлын агуулга	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлын талаар танилцуулга	11:00-11:05	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн 2025 оны тоот тогтоолоор батлагдсан Хурлын дарга, Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг танилцуулж, тооллогын комиссыг ажилдаа орохыг мэдэгдэнэ.
2	Хуралд оролцогчдыг бүртгэх, “Ирцийн тухай” тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулна.	11:05-11:20	Тооллогын Комиссын дарга Б. Юмжирдулам
3	Хурлыг нээх, хуралд оролцож байгаа ТУЗ-ийн гишүүд, Компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудыг танилцуулах.	11:20-11:30	Хурлын дарга Д.Батхуяг
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2025 оны төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар танилцуулга	11:30-12:30	Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэ
5	Асуулт, хариулт	12:30-13:00	Асуултад ТУЗ-ийн дарга, Аудитын хорооны дарга, Гүйцэтгэх захирал хариулна.
6	Цайны завсарлага	13:00-13:30	
7	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийн тухай	13:30-13:45	Д.Энхтогтох-ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга

8	Асуулт, хариулт	13:45 -14:00	
9	ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг танилцуулах	14:00-14.15	Хурлын дарга
10	Асуулт, хариулт	14:15-14:20	
11	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын талаар	14:20-14:35	Хурлын дарга таницуулна (Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 4 сарын 02-ны өдрийн "ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай" 04 тоот тогтоолыг хэвээр мөрдөж ажиллана)
12	Асуулт, хариулт	14:25-14:30	Хурлын дарга, Гүйцэтгэх захирал
13	Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-ийн 2024 оны 01 тоот тогтоолыг танилцуулах	14.30-14.45	Гүйцэтгэх захирал Ногдол ашиг хуваарилахгүй болсон үндэслэлээ танилцуулна.
14	Тооллогын комисс ажилдаа орж, хэлэлцэх асуудал бүрээр санал өгсөн дүнг танилцуулна.	14:45-15:15	Тооллогын комисс ажиллана. Аргачлал өгнө.
15	Хэлэлцсэн асуудлаар гарах тогтоолыг уншиж батлуулах	15:15-15:30	Хурлын дарга
16	Хурал хаах	15:30-15:35	Хурлын дарга



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

1. “Хөвсгөл алтандуулга” ХХ-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоол
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
3. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын тайлан
4. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай ХЭХ-ын тогтоолын төсөл №01
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай ХЭХ-ын тогтоолын төсөл №02
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай ХЭХ-ын тогтоолын төсөл №03
7. “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот тогтоол
8. Компанийн 2025 оны зорилт болон үйлдвэрлэлийн төлөвлөгөө, зардлын төсвийн талаар
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2025.03.13

№ А.3

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, 60.2, 60.3, 76.1.2 дахь заалтыг үндэслэн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны
04 дүгээр сарын 25-ны өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал багт
байрлах “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2025 оны
төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар танилцуулга
\\Танилцуулах нь: Г.Бат-Эрдэнэ - Компанийн Гүйцэтгэх захирал\\
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн
гаргасан дүгнэлтийг батлах тухай
\\Танилцуулах нь: Д.Энхтогтох-ТУЗ-ийн гишүүн, Аудитын
хорооны дарга\\
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох
тухай
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\
- “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар
сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолын талаар
\\Танилцуулах нь: Д.Батхуяг- ТУЗ-ийн дарга\\

3.Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа
эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт, хэлэлцэх асуудлаар санал өгөх
“Саналын хуудас”-ны агуулгыг 1, 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд
оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04
дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хурлын зарыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, өөрийн компанийн цахим хуудсаар, 2025 оны 03 дугаар сарын 24-н өдөр болон 04 дүгээр сарын 9-ний өдөр “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх баримт бичгийг бэлэн болгох эцсийн хугацааг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39-2, “Велокс” оффисын 8 давхарт болон Хөвсгөл аймгийн Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцаж болохыг дурьдсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн урьдчилж өгөх саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 11:00 цаг байхаар тогтсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батхуягийг, хурал зохион байгуулах комиссын даргаар Компанийн гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнийг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн тооцооны нягтлан бодогч Б.Юмжирдулам, гишүүдээр мөн компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Анужин, “Алтан хажир” ХХК-ийн нягтлан бодогч Б.Сарангарав нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Д.БАТХУЯГ





“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны
03 сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолын 02 дугаар
хавсралт

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОГЧДООС
САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчдийн овог нэр
Регистрийн дугаар
Санал өгөх хувьцааны тоо
Үйлчилсэн / Үнэт цаасны компани /
“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд болно.

№	Хэлэлцэх асуудал	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн	Тагталзсан	Тагталзсан бол таны өгөх санал
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай	Тогтоол №01				
2	ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай	Тогтоол №02				
3	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай	Тогтоол №03				

(Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигч..... Гарын үсэг

2025 оны 04 дүгээр сарын-ны өдөр

Санал авах хуудсыг ашиглах санамж: Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр ирж хуралд оролцох боломжгүй бол 2025 оны 04-р сарын 23-ны өдрийн 11.00 цагаас өмнө “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн УБ хот болон орон нутгийн байранд очиж, хурлын материалтай танилцан санал авах хуудсаар саналаа өгнө. Хэрэв өөр хүнээр төлөөлүүдэх бол тухайн хүндээ итгэмжлэл өгч нотариатаар батлагаажуулсан байна. Засварласан болон балласан санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№ 01

Тариалан сум

Компанийн жилийн үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт, “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн дүрмийн 7.8.3 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас
ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” хувьцаат компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.
2. Тус компанийн 2024 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэхийн зэрэгцээ Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтэд гарсан санал, өгөгдсөн үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн удирдлагуудад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.БАТХУЯГ

КОМПАНИЙ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангаас “шинээр болон өмнө эхлүүлсэн ажлын явц, үр дүн, санхүүгийн байдал”-тай танилцав. Гүйцэтгэх удирлагын баг санхүүгийн болон санхүүгийн бус нөөцийг үр дүнтэй зүй зохистой ашиглахыг зорьж ажилласан байна.


Үйл ажиллагааны тайланд дурьдсан газар тариалан, боловсруулах үйлдвэрийн шат дамжлагын хэсэгт хийсэн технологийн шинэчлэлийн болон урсгал засварын ажлууд бүтээгдхүүний өртөг зардлыг бууруулах, хүний хүчин зүйлийн оролцоог эерэг талаас нь дэмжсэн “хөрөнгө оруулалт” болжээ.

Байгууллага сүүлийн жилүүдэд “хэсэгчилсэн байдлаар бүтцийн өөрчлөлт” үе шаттай хийж, газар тариалан болон боловсруулах үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, нэгж тус бүр үр ашигтай ажиллаж байхыг гол зорилго болгож байгаа билээ. Ирэх жилүүдэд “үйл ажиллагааны чиглэл тус бүрээр буюу нэгж бүр” төлөвлөлт, хүлээж буй үр дүн, гүйцэтгэлийг зэрэгцүүлсэн байдлаар хэмжиж дүгнэж, харьцуулахуйц, динамик байдлаар тодорхойлж, нэгтгэлийн доторх тоонууд “ямар үр дүн, өгөөжтэй эсэх”-ийг мэдээлж байх нь чухал байна.

Тайланд төлөвлөсөн зорилтуудаа агуулгын хүрээнд биелүүлж, санхүүгийн хувьд давагдашгүй хүчин зүйлийг эс тооцвол тогтвортой байдлаа хангахыг чухалчлан ажилласан байна.

Тайлангийн чанарын үзүүлэлт 2024 онд сайн байна.

Графикт үйл ажиллагаа болон санхүүгийн гол үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэв.



2024 онд урт хугацаатай, өртөг багатай зээл, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн дутагдал хэвээр байсан ба импортын татварын шинэ бодлого хэрэгжүүлсэн нь үндэсний үйлдвэрлэгч, стратегийн салбарын “тогтвортой хөгжиж буй нэг жижиг хэсэг”-ийн хувьд хүнд цохилттой тулгарсан байна гэж үзлээ.

2024 онд өглөг авлагын насжилт, эргэлт тал дээр чанарын ахиц гаргаж, байгаа нөөцөө оновчтой удирдан зохион байгуулж, ашигтай ажилласан байна.

Уламжлалт тогтвортой байдлаа эргэн харж, “улирлын чанартай үйл ажиллагаа, орлогоос хараат бус байх боломж, нөөцөө үр ашигтай ашиглах хувилбар”-ыг судлан хэрэгжүүлэх асуудлыг олон талаас нээлттэй ярилцаж шийдвэрлэхийг зөвлөж байна.

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№ 02

Тариалан сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.12, 65.6.6 дахь заалтыг үндэслэн “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг 121,348,380,00 \Зуун хорин нэгэн сая гурван зуун дөчин найман мянга гурван зуун наяд\ төгрөгөөр баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.БАТХУЯГ

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

№ 03

Тариалан сум

**ТУЗ-ийн гишүүдийн цалин
урамшууллын тухай**

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.7, 7.44-д заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2025 оны цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцооны нэмэгдлийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай” 04 дүгээр тогтоолын дагуу олгож байхаар тогтсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тогтмол цалин, урамшуулал, нэмэгдлийг жилийн эцэст, оролцооны нэмэгдлийг тухай бүр олгож байхыг ерөнхий нягтлан бодогч Ж.Отгоннямд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Д.БАТХУЯГ

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН,
УРАМШУУЛЛЫН ТУХАЙ**

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаа, санаачлагыг идэвхжүүлэх, аливаа асуудалд ажил хэрэг, бүтээлчээр хандах хандлагыг дээшлүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэх, зохион байгуулсан ажилд оролцсон оролцоо, ажлын үр дүнг үнэлж, урамшуулах зорилгоор Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, ХК-ийн дүрмийн 7.8.7, 7.44 дэх заалтын дагуу тэдэнд цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцоог харгалзан тодорхой нэмэгдэл олгож байхаар 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 04 тоот тогтоол гарган хэрэгжүүлж байгаа юм. Дээрх тогтоолоор:

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН
ЦАЛИН, УРАМШУУЛАЛ, НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ**

ТУЗ-ийн гишүүдийн цалин, нэмэгдэл		Хэмжээ, хөлбөгдөх шимтгэлийг суутгасан байдлаар /төг/
Сард олгох тогтмол цалин ба нэм	Энгийн гишүүд	50,000
	Хараат бус гишүүд	70,000
	Хороодын даргын нэмэгдэл	30,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	30,000
Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	50,000

байхаар тогтоосон юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2025.02.18

№ 01

Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай.

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А\25-21 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь.

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 420 гаруй сая төгрөгийн ашигтай ажиллаж, алдагдлыг өмнөх онтой харьцуулахад 3.2 дахин бууруулсан зэрэг зарим ахиц гарсан боловч цаашид хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг бага эрсдэлтэй, үр өгөөжтэй байлгах, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, компанийн үйл ажиллагааг илүү тогтвортой болгох зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Ногдол ашиг хуваарилахгүй болсон үндэслэл, энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахаар тогтсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.БАТХУЯГ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2025-02-18

№ А/25-21

Хөвсгөл Алтандуулга ХК-ний ТУЗ болон гишүүдэд

Ногдол ашиг тараахгүй байх үндэслэл, тайлбар

Хөвсгөл Алтандуулга ХК нь зах зээл дэх гурилын хамгийн хямд үнийг санал болгох, орон нутаг дахь тэжээлийн борлуулалтын зах зээлийг эзлэх бодлогыг үргэлжилүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ зардалыг багасгах, үр ашигтай ажиллахыг зорин ажилласанаар борлуулалтын орлогыг 4.2 хувиар нэмэгдүүлж, өртөгийг 5.4 хувиар, удирдлага, борлуулалтын зардалыг 23.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 426,6 сая төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх онтой харьцуулахад алдагдалыг 3.2 дахин бууруулсан ба санхүүгийн тоон мэдээлэл, бүртгэл үнэн зөвийг хөндлөнгийн аудитаар баталгаажсан болно.

2024 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайланг хураангуй байдлаар, өмнөх онтой харьцуулсан байдлаар харуулвал.

	/сая төгрөгөөр/	
	2023 он	2024 он
Борлуулалтын орлого	10,368.9	10,803.4
Борлуулалтын өртөг	8,802.3	9,282.4
Борлуулалтын ашиг	1,566.5	1,520.9
Бусад орлого	520.1	320.0
Ерөнхий удирдлагын зардал	777.9	1074.2
Борлуулалтын зардал	510.4	514.2
Санхүүгийн зардал	938.7	807.7
Бусад зардал	16.5	12.6
Валютын ханшийн ашиг/алдагдал	74.0	-4.6
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз		1,057.9
Татварын зардал	3.3	59.0
Татварын дараах цэвэр ашиг/алдагдал	-234.3	426.6

Хэдийгээр 2024 онд ашигатай ажилласан ч сүүлийн жилүүдэд алдагдалтай ажиллахад хүргэж байсан ББСБ-ын богино хугацааны өндөр хүүтэй зээл, ОХУ-аас импортолж буй таваарын улаанбуудайн төлбөрийн ханшийн зөрүү, ХААДС-аас бэлэн мөнгөөр таваарын улаанбуудай худалдан авч үйлдвэрлэлээ явуулах, жил жилд өсөж буй түүхийн эдийн үнийн өсөлт, түүнийг нийлүүлэгч тариаланчдын төлбөрийг богино хугацаанд төлж зах зээлд хадгалан үлдэх, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй ажиллах хүчний хомсдол, газар тариаланд сүүлийн жилүүдэд байнга нүүрлэж буй байгалийн давагдашгүй хүчин зүйл болох үер, ган зэргээс үүдэлтэй түүхий эдийн өртөгийн нэмэгдэл гэх мэт шалтгаанууд нь мөнгөн хөрөнгийн дутагдалыг бий болгон үйл ажиллагааны цар хүрээг багасган хумиж байна.

Иймд бид хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг бага эрсдэлтэй, үр өгөөжтэй байлгахын тулд энэ жилийн ашгийг эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд зориулж үйл ажиллагааг илүү тогтвортой болгох, зах зээлд шаардлагатай жижиглэнгийн 1кг-н автомат савалгааг үйлдвэрлэлд угсрах, цаг хугацаа, хүний оролцоог багасгах зорилгоор ургамал хорио цээрийн лабораторт шаардлагатай пертен аппарат авах зэргээр хүний нөөцийн дутагдал асуудалыг шийдвэрлэх зэргээр үйл ажиллагааг өсөн нэмэгдүүлэхэд зарцуулахаар зорьж байгаа тул ноогдол ашиг хуваарилахгүй байх шийдвэр гаргаж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БАТ-ЭРДЭНЭ



2024 оны ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



АГУУЛГА

- 2024 оны онцлох үйл явдал
- 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл
- Засаглалын үйл ажиллагаа
- Хамтын ажиллагаа
- Стратеги зорилтууд



КОМПАНИЙН ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА



	“Хөвсгөл Алтандуулга” ХК
Улсын бүртгэлийн дугаар	1710001001
Регистрийн дугаар	2034565
Үүсгэн байгуулагдсан огноо	1996.04.25
Үйл ажиллагааны чиглэл	Үр тариа үйлдвэрлэл
	Гурил үйлдвэрлэл
	Малын тэжээлийн үйлдвэрлэл
	Хүнсний ногоо тариалах
	Гадаад дотоод худалдаа
	Малын аж ахуй
	Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа
Хувь нийлүүлсэн хөрөнгө	157,342 мянган төгрөг
Компанийн хаяг	Хөвсгөл, Тариалан, Мандал
Холбоо барих утас	70386030, 77116031
Хувьцаа эзэмшигчдийн тоо	489 хувьцаа эзэмшигчидтэй (2024.12.31 байдлаар)

2024 оны онцлох үйл явдал



Ажилчдын байрны Халаалтын 120м үндсэн шугамыг үйлдвэрт өгөх шугамнаас салган нэгдсэн халаалтын төвтэй холбон ф50 хоолойг ф100 хоолойгоор өргөтгөсөн дулааны шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэв



Цагт 2тн үр тариа бяцлах тоног төхөөрөмжийг ОХУ-аас импортлон тэжээлийн үйлдвэр дотор суурилуулсанаар жил бүрийн намар үүсдэг малчдын эрэлт хэрэгцээг хангах асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэв.



Үтрэмийн Силосны буудай хүлээн авах хэсэгт 1 цагт 100тн улаан буудай цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэгээний машин суурилуулав.



МУ-ын шилдэг хүнс үйлдвэрлэгч 10-н ААН-ийн нэг болж хойд бүсийн “ХАА-н САЛБАРЫН ШИЛДЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧ”, Шагнал.



Хөвсгөл аймгийн Тариалын сумын “2024 ОНЫ ШИЛДЭГ ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧ” өргөмжилөл шагналыг тус тус авав.


2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл

Газар тариалангийн үйлдвэрлэл

- 2024 онд өөрсийн санхүүгийн боломжид тулгуурлан нийт 2691 га-д тариалалт хийж , хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, бүтээгдхүүний чанарыг сайжруулахад анхаарав. 2691 га талбайгаас улаан буудайн 7 сортын үрээр 2574 га-д, овьёос 55 га, арвай 25 га , ногоон тэжээл 36,3 га-д тус тус тариалав.
- Тариалалтанд шаардлагатай үрийн буудай 516 тн-ыг ХААК -иас гэрээ хийн авсан ба элит ангилалын үрийн буудай 3 сорт 56 тн, дотоодын 3 сортын 460 тн үрийг авав.
- Сибукторн ХХК-тай хамтран ажиллаж нийт 860 га, талбайг хашаажуулав.



Таримлын төрөл	Тариалалт /га/	Ургац /тн/
Улаанбуудай	2,574	2,379.0
Халтар арвай	25	5.75
Овьёос	36	58.0
Тэжээлийн ургамал	55	73.0
Нийт	2,690	2,515.75



2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл


Боловсруулах үйлдвэрлэлт

- 2024 онд нийт 4,330,687тн түүхий эдийг боловсруулах үйлдвэрт хүлээн авч ус дулаанаар боловсруулах болон цэвэрлэж, эцсийн бүтээгдэхүүн үйлдэрлэв.
- Нийт 5 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс

Дээд гурил	1-р гурил	3-р гурил	Бүхэл үрийн гурил	Хивэг тэжээл
3%	69,8%	2%	4%	21%

- Боловсруулах үйлдвэрийн гарц, цагийн бүтээмжийг нэмэгдүүлэх үйлдвэрийн элэгдэл хорогдлыг тооцуулах зорилгоор БНХАУ-аас мэргэжилтэн ажиллуулж цагийн хүчин чадлыг 1 дахин нэмэгдүүлэв.

- Нийт тээрэмдсэн улаанбудайн 79.4% нь гурил, 20.6% тэжээлийн хивэг үйлдвэрлэсэн ба ТЭМ-ийн хангалтын 31,2 хувийг өөрийн газар тариалангаас, 33,1 хувийг ААН, иргэнээс, 35,7 хувийг ХААК-аас тус тус худалдан авсан байна.



	2020	2021	2022	2023	2024
Тээрэмдсэн буудай	6,669	8,134	8,611	4,748	4330.7
1-р ба дээд гурил	4,737	5,346	5,895	3,222	3091.6
2,3-р гурил	401	311	200	359	180.6
Бүхэл үрийн гурил	70	85	109	101	168.1
Хивэг	1,461	2,301	2,294	1,066	890.4
Хаягдал		91	114		

ҮТРЭМ



- Хаврын тариалалтын ажилд үрийн улаан буудай цэвэрлэх, бордох ариутгах зэрэг ажлууд технологийн дагуу хийгдэв. Мөн ААН, хувь хүний үрийн улаан буудайг, ариутгах, бордох ажлыг давхар хийж гүйцэтгэлээ.
- Комфост бордоо бэлтгэх ажилд бууц зөөж нөөцлөв.
- АА-н нэгж, Иргэдээс хүлээн авсан хүнсний улаан буудайг лабораторийн шинжилгээгээр ангилан талбайд байрлуулж цэвэрлэж, сортлон хадгалалтанд шилжүүлэв.
- 2024 онд хийгдэх төлөвлөгөөт ажил авто өргөгчийн доод хэсэг, тэжээлийн үйлдвэрийн бэлтгэл хэсгийн цементэн талбайн цутгалтын ажлыг хийв.





Боловсруулах үйлдвэрийн гадаад сэлбэг захиалга болон үтрэмийн буудай хүлээн авах хэсгийн цэвэрлэгээг сайжруулах улаанбуудайн стандарт MNS;0097:2010 нийцсэн түүхий эдийг үйлдвэрт шилжүүлэх зорилгоор БНХАУ-с TXZS 200\250 маркын улаан буудай цэвэрлэх тоног төхөөрөмж болон боловсруулах үйлдвэрийн сэлбэг захиалан суурьлуулж хэвийн ажиллагаанд оруулав.

Мөн 8-10 тн/цаг хүчин чадалтай, үр тариа нэг цэгээс нөгөө цэг рүү зөөвөрлөх төхөөрөмжийг ОХУ-аас авч суурилуулав.

Бэлэн бүтээгдэхүүн хадгалах хураахад зориулан 50ш модон поддоныг өөрийн нөөц бололцоонд тулгуурлан цаашид удаан эдэлгээ даах чанартай байлгах зорилгоор 5 ажилтан 8 өдөрт багтаан хийж гүйцэтгэв.


ЛАБОРАТОРИ

- Энэ онд иргэн аж ахуйн нэгжээс хүлээн авсан улаан буудайн 317 сорьцод давхардсан тоогоор 7 үзүүлэлтээр, үйлдвэрлэлийн шат дамжлагын хяналтаар улаан буудайд 7 үзүүлэлтээр 2957 сорьцод, бэлэн бүтээгдэхүүний хяналт шинжилгээг давхардсан тоогоор 5 үзүүлэлтээр 6001 сорьцод цаг хугацаанд нь батлагдсан стандарт арга аргачлалын дагуу халдвар хамгаалал аюулгүй ажиллагааны дэглэмийг нарийн баримтлан чанартай хийж гүйцэтгэн, сорилтын дүн хариуг хугацаанд нь гарган ажиллаж байна. Мөн тарих үрийн чанар, хорио цээрийн шинжилгээг гүйцэтгэсэн.
- Намрын ургац хураалтаар хүлээн авсан түүхий эдийн чанарын үзүүлэлтийг хадгалалтын орчинтой зурагжуулав.
- MNS ISO/IEC 17025:2018 Дагуу лаборатори хооронд харьцуулсан шинжилгээг Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн газрын сорилтын лабораторитой тарих үрийн чанар болон бүхэл үрийн гурилын чанарыг тодорхойлох үзүүлэлтээр үр дүнг тооцон ажиллав.
- ХАБҮЛЛ Стратеги төлөвлөлтийн газраас жил бүр уламжлал болгон зохион явуулдаг ур чадварын сорилт хөтөлбөрт 24-ХЦ17 кодтой таримал ба хог ургамлын тоо тодорхойлох шинжилгээгээр хамрагдан, сорилтод тэнцсэн үзүүлэлтээр гэрчилгээг авсан.





Гурилын борлуулалт

- 2024 онд Мөрөн дэх дэлгүүр гурил тэжээлийн борлуулалтыг толгой компанитай гэрээгээр хийж гүйцэтгэж эхэлсэн бөгөөд зах зээлд эрэлттэй борлуулалттай, үндсэн борлуулалтыг дэмжих бараа бүтээгдэхүүнийг давхар борлуулаад байна.
- Шинээр талхны цехийг ажиллуулан хэрэглэгчдэд өдөр бүр шинэ, нэрийн талхыг хүргэхээр туршилт, судалгааны ажил хийгдсээр оны эцэс гэхэд өөрийн тодорхой хэрэглэгчтэй болж эхэллээ.
- Бүтээгдэхүүний хүргэлтийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгохоор зорин ажиллаж байна.



Газар тариалангийн борлуулалт

- Газар тариалангаас авч буй таваарын буудайн ургацыг өөрийн гурилын үйлдвэрт нийлүүлдэг бол газар тариалангийн бусад ургамлын борлуулалтыг Алтанхажир ХХК өөрөө бие даан хийдэг.
- Мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор жил бүр тодорхой га талбайг ойр орчмын ААН, иргэдэд түрээсэлдэг ба 2024 онд түрээсийн нийт орлого 16%-ийг эзлэж байгаа ба 317 сая төгрөгт хүрсэн байна.




ХҮНИЙ НӨӨЦ


Нийт ажилтаны 44% нь дээд боловсролтой болон МСҮТ төгссөн, 71% нь 6 жилээс дээш хугацаанд ажилласан нь хүний нөөцийн тогтвортой, чадварлаг баг бүрдсэнийг илтгэж байна. 2024 онд Хүний нөөцийн эргэцийн дундаж хувь 3.3-тай буюу хүний нөөц тогтвор суурьшилтай байгааг харуулж байна.

2024 онд цалингийн доод хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан 20%, намар үтрэмийн ажилтаны цалинг 20-25%-иар шатлалтайгаар 2 удаа тус тус нэмэгдүүлсэн.


Хүйсийн харьцаа




Ажилласан жил



Насжилт



Харьцуулалт / сая төгрөг



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цалин дунджаар 17% өссөн

ХҮНИЙ НӨӨЦ



Идэвхижүүлэлт

1. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнийг аймгийн хэмжээнд нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, нийт 30 гаруй багийн 200 орчим тамирчид амжилттай оролцсон.
2. 2024 оны “Ажилчдын нэг өдөр” 6 төрөлт тэмцээнийг уламжлал ёсоор амжилттай зохион байгуулав.
3. 2024 оны 7 болон 8 сард 2 ээлжээр УБ хот Рехамед эмнэлэгтэй хамтран нийт 40 ажилтныг нэгдсэн журмаар эрүүл мэндийн тогтсон үзлэгт хамрууллаа.



Сургалт

Гадны байгууллагаас авсан сургалт:

- НД-н шимтгэл, түүнээс олгох тэтгэмж - Сумын НД-н байцаагч Э.Энхзаяа
- Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх-СЭМТөвийн эмч нар

Дотоод сургалт:

- ХАБЭА-н анхан шатны сургалт – Үйлдвэрийн дарга П.Батхуяг
- Хөдөлмөрийн дотоод журам танилцуулага – ХНМ Б.Энхмөрөн
- Ажлын байран дахь ёс зүйн дэг – ХНМ Б.Энхмөрөн
- Бусдад туслахын ач холбогдол ХНМ Б.Энхмөрөн
- Итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаа – Лабораторийн эрхлэгч Э.Баасанжаргал



САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Компанийн 2025 оны санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-өөр батлуулав.
- Компанийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд Пантер Мидланд Аудит ХХК-иар хөндлөнгийн аудит хийлгэлээ.
- Нийт 10.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 9.3 тэрбум төгрөгийн өртөг гаргаж, 1.5 тэрбум төг-ийн нийт ашигтай, 0.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
- 2024 онд борлуулалт, ерөнхий удирдлагын зардалыг 20.3%-иар нэмэгдсэн, энэ онд татварт нийт 170.3 сая төгрөг, нийгмийн даатгалд 218.6 сая төгрөгийг төлж, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

	2023 он мян төг	2024 он мян төг
Үр тариа, тэжээлийн борлуулалт	2,227,847.9	2,340,570.6
Гурил, хивэг борлуулалт	8,141,028.1	8,462,829.9
Борлуулалтын орлого	10,368,876.0	10,803,400.5
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,802,323.9	9,282,439.8
Нийт ашиг	1,566,552.1	1,520,960.7
Ерөнхий удирдлага, борлуулалтын зардал	1,288,298.9	1,588,506.9
Санхүүгийн зардал	938,741.2	807,687.9
Үйл ажиллагааны бус орлого/зардал	429,509.1	1,360,665.9
Татварын өмнөх орлого	(230,978.9)	485,685.0
Татварын зардал	3,307.8	59,082.0
Тайлант үеийн цэвэр ашиг	(234,286.7)	426,603.0

Хөрөнгө, өр төлбөрийн байдал

- Компанийн өөрийн хөрөнгө хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжсэн дүнгээр 0.9 тэрбум төгрөгөөр буурч, хуримтлагдсан шиг 0.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Өмнөх онд бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан улаанбуудайн 1,5 тэрбум төгрөгийн өр төлбөрийг төлж дуусгав. ХААДС-тай байгуулсан гэрээний үндсэн дээр 1,7 тэрбум төгрөгийн таваарын улаанбуудайг худалдан авч үйлдвэрт нийлүүлсэн.
- Оны эцэст буудайн дансны өглөг 1.8 тэрбум төг, бусад богино хугацаат өглөг 6.5 тэрбум төг, урт хугацаат өр төлбөр 0.001 тэрбум төг болж, нийт 8.3 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байна.
- Ингэснээр нийт хөрөнгө, өр төлбөр 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар 15.4 тэрбум төг болсон байна.

Сүүлийн 5-н жилийн тоон үзүүлэлт


Борлуулалтын орлого
тэрбум төгрөг



Цэвэр ашиг, сая.төгрөг



Төлсөн татвар
сая.төгрөг



Төлсөн НДШимтгэл
сая.төгрөг



ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Хувьцааны ханш 2024 онд 407-240 төгрөгийн хооронд арилжаалагдсан байна.



ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага болох Төлөөлөн Удирдах Зөвлөл нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон Санхүүгийн зохицуулах хорооноос болон ХЭХ, ТУЗ-өөс гаргасан дүрэм, журмуудыг мөрдөж ажиллаа.

Компанийн засаглалын кодексын хэрэгжүүлэхэд ТУЗ-ийн дэргэдэх хороод, Гүйцэтгэх удирдлагын зүгээс анхаарч ажиллав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2024 онд 5 удаа хуралдсан ба зайлшгүй яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлыг ТУЗ-ийн гишүүдэд цахим шуудангаар явуулж, саналын хуудсаар танилцуулсаны үндсэн дээр эчнээ хурал хийж, нийт 17 тогтоол гаргажээ.

Гурил үйлдвэрлэлийн түүхий эдийн тасралтгүй байдлыг хангахад зориулж ХААК ТӨХХК-иас хүнсний буудай зээлээр худалдан авах талаар холбогдох тооцоо, судалгааг хийж, эрх бүхий байгууллагад хандсан тогтоолыг гаргав. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2023 оны санхүүгийн урьдчилсан тайланг харгалзан Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэж, энэ талаар Хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэв.

“Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн ажилтан, ажилчдын цалинг тодорхой хувь, хэмжээгээр үе шаттай өсгөж, цалингийн санг 2024 оны батлагдсан төсвөөс Зуун сая хүртэл төгрөгөөр нэмэгдүүлэхээр ТУЗ-өөс тогтоол гаргав. Цалинг нэмэгдүүлэхтэй холбоотой төсвийг компанийн дотоод эх үүсвэр, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс гаргахаар шийдвэрлэв.

Тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Н.Одончимэгийн өөрийнх нь хүсэлтийг харгалзан ажлаас нь чөлөөлж, Гүйцэтгэх захирлаар Г.Бат-Эрдэнийг томилов. Энэхүү шийдвэрээ эрх бүхий байгууллагад хүргүүлэв.

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн охин компани болох “Монгол Фармерс Маркет” ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталж, ТУЗ-ийг нь байгуулан, Гүйцэтгэх захирлаар Н.Баатар-Очирыг томилж шийдвэрлэлээ.

Компанийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид хэрэгжүүлэх ажлыг оновчтой тодорхойлох, зөвлөмжийг ТУЗ-ийн зүгээс тогтмол өгч ажиллав.

Компанийн бүтэц зохион байгуулалттай холбоотой асуудлаар боловсруулсан баримт бичгийн төсөл, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбогдуулж ТУЗ-өөс гаргах дүгнэлт, ажилтан, албан хаагчдын цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудлууд, удирдах албан тушаалтны томилгооны асуудлаар ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хорооны гишүүдэд урьдчилан танилцуулж, тэдний саналыг авч ажилласан болно.

Магадлан итгэмжлэх лабораторийг өргөжүүлэн ашиглалтад бүрэн оруулсан нь газар тариалан, боловсруулах үйлдвэрийн шат дамжлага бүрт чанар, стандартыг мөрдөх, хянах, зэрэгцүүлсэн дүгнэлт хийх зэрэг олон талын ач холбогдолтой чухал хөрөнгө оруулалт болж чадсан байна. Хаврын тариалалт, түүний бэлтгэл ажил, тариалалтын явц, намрын ургац хураалтын ажилтай ТУЗ-ийн дарга болон зарим гишүүд тогтмол танилцан, үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажилласан болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11 цагт Хөвсгөл аймгийн Тариалан суманд хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлэв. Үүнд:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2024 оны төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын тухай
- “Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай” ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолыг танилцуулах

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг эрх бүхий байгууллагаас гаргуулан авах, хурлын зарыг хуульд заасан хугацаанд нь Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын сониноор хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, холбогдох бичиг баримтыг бэлэн болгож хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, үнэт цаасны компаниудад хүргүүлэх, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг баталж, урьдчилж саналаа өгөх боломжоор хангах ажлыг зохион байгуулж ажилласан байна. Ээлжит хурлын өмнө ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргын зүгээс компанийн хувьцаа эзэмшигч 20 гаруй хүнтэй биечлэн уулзаж, мэдээлэл өгч, тэдний санал, хүсэлтийг сонсож ажиллав.

ТУЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийг гаргуулан, 2024 оны зардлын төсвийг боловсруулан ХЭХ-аар батлуулав. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг 83,550,000 төгрөгөөр батлав. Мөн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 04 тоот тогтоолын дагуу олгож байхаар шийдвэрлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 8 583 575 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 13 хувьцаа эзэмшигч оролцож, 2 263 482 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 11 хувьцаа эзэмшигч урьдчилан саналаа ирүүлснээр нийт саналын эрх бүхий 14 950 655 ширхэг энгийн хувьцаанаас 10 847 057 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 24 хүн оролцож хурлын ирц 72.5 хувийн байв. ХЭХ нь хуулийн хүчинтэй болж төлөвлөсөн асуудлуудаа амжилттай хэлэлцэж, зохих шийдвэрийг Хувьцаа эзэмшигчид 100 хувь дэмжсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг хуулийн хугацаа болох 3 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлж ажилласан болно. Хурлын шийдвэрийг Хөрөнгийн биржийн цахим хуудас болон өөрийн компанийн цахим хуудаст байршуулав.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Мөн үтрэмийн силос хэсгийн түүхий эд хүлээж авах хэсгийн буудай 3 давхар цэвэрлэх байгууламжийг бүрэн шинэчлэхээр БНХАУ-ын KAIFENG AOHUA MACHINERY CO.,LTD-тай хамтын ажиллагааг эхлүүлээд байна.
2. Бэлэн бүтээгдэхүүний агуулахын өргөтгөл хийхээр төлөвлөж "ЭМ ЭЙ ДИ АТЕЛЬЕР" ХХК-тай гэрээ байгуулан эскиз зургийн батлуулж, одоогоор ажлын зураг хийгдээд байна.
3. НҮБ-ын ХАА-н байгууллагаас Хөвсгөл аймгийн 3 суманд хэрэгжүүлэх төслийн СТРИЙМ төслийн багтай Тэжээлийн үйлдвэрийн төсөлд хамтран ажиллахаар ярианы түвшинд тохирон хүсэлтийг албан ёсоор илэрхийсэн.

Алтан Хажир ХХК нь газар тариалангийн үйлдвэрлэлийн технологи шинэчлэл, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, тогтвортой ургац авах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Тогтвортой ургац төв ХХК-тай хамтран ОХУ-ын Эрхүү мужид нэвтрүүлж буй шинэ технологийг өөрийн нөхцөлд нэвтрүүлэхээр хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мөн Энсада трактрон, ХААК, Агротрейд ХХК, Шунхлай Петролиум, МСМ ХХК, Агромакс ХХК, Хан дээж ХХК, Норбу тоног төхөөрөмжийн компаниудтай үйлдвэрлэлийн орцууд, болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сонголт нийлүүлэлт дээр хамтран ажиллаж байна.

БНХАУ-ын газар тариалангийн үйлдвэрлэлийн шинжлэх ухааны академитай орон нутгийн онцлогт тохирсон чанартай үр үржүүлгийн чиглэлээр, Huilong group –тэй нийлмэл бордоо нийлүүлэхэд хамтран ажиллаж бүтээгдэхүүнийг Хөвсгөл Алтандуулга ХК-иар дамжуулан худалдан авалт хийн хэрэглэв.



Food and Agriculture
Organization of the
United Nations



СТРАТЕГИ ЗОРИЛТУУД



- Компанийн хэмжээнд нэгжүүдийн уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод хяналтын системийг бүрдүүлж баг байгуулан ажиллана.
- Итгэмжлэгдсэн лабораторийг дахин итгэмжлүүлж, ургамал хорио цээрийн лабораторийн ажлын хүрээг өргөтгөн хүний нөөцийг чадавхижуулж ажиллах

Гурилын үйлдвэрлэлийн чиглэлд

- Үйлдвэрлэлийн процессыг хагас автоматжсан горимд шилжүүлэх ажлыг санхүүгийн нөөц боломжинд тулгуурлан хэсэгчилэн шийдвэрлэж ажиллана.
- Үйлдвэрийн чанар, эрүүл ахуй, MNS ISO9001:2015 стандартыг бүрэн хангуулах, үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хагахад нийцүүлэн барихаар төлөвлөсөн Агуулахын өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг олох
- Тэжээлийн үйлдвэрлэлийн орчин үеийн техник технологийг судлах, төсөл хөтөлбөр боловсруулах, хамрагдах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, бүс нутаг дахь малын тэжээлийн зах зээлд томоохон байр суурь эзлэх.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлд

- Бага га-аас өндөр ургац авах. ОХУ-аас гарц өндөртэй, эрт болцын шинэ сортын үр тариаг туршилтаар тарихаар төлөвлөж байна.
- Хөрс хамгаалах, хөрсний үржил шимийг сайжруулах шинэ технологийг нэврүүлэх төлийн хүрээнд зөвлөмжийг хэрэгжүүлж, технологийг мөрдөж ажллана.
- Технологи нэвтрүүлэхтэй холбоотой техникийн шинэчилэлтийг хийнэ.
- Технологийн ажилд оролцогч оператор, агронамич нарын ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнд тулгуурлан цалин хөлс, урамшуулалыг олгодог системийг бий болгон шинэчилэн ажиллана.
- Тариалалтын бүх талбайг хашаажуулж дуусгана.

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2025.02.13

№ 25/04.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Хөвсгөл Алтандуулга" ХК болон түүний охин компани "Алтан Хажир"ХХК, "Монгол Фермерс Маркет" ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 10-30 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Групп нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн багалгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалтай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал

ирээдүйд үүсэж болох юм.

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.


Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.


"Пантер Мидланд Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг



(төгрөгөөр)

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН
"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК
 (Аж ахуйн нэгж байгууллагын нэр) (төгрөгөөр)

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024
ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	84,659,904.65	179,170,939.64
Дансны авлага	2,751,980,789.44	3,297,039,136.02
Татвар, НДШ-ийн авлага	127,298,702.78	62,684,035.00
Бараа материал	4,396,667,430.94	3,814,335,146.29
Урьдчилж төлсөн зардал/тсоцоо	550,094,729.37	588,966,239.92
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,910,701,557.18	7,942,195,496.87
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	7,155,227,070.93	6,454,376,241.30
Биет бус хөрөнгө	938,977,708.47	574,329,535.24
Биологийн хөрөнгө	107,279,000.98	194,794,943.37
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
Дуусаагүй барилга	0.00	199,002,188.46
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,202,483,780.38	7,423,502,908.37
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,113,185,337.56	15,365,698,405.24
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2,350,056,779.43	1,818,050,627.83
Цалингийн өглөг	0.00	0.00
Татварын өр	164,404,909.21	221,261,241.64
НДШ-ийн өглөг	0.00	8,645,821.24
Богино хугацаат зээл	2,953,249,522.78	4,149,694,212.02
Хүүгийн өглөг	1,030,165,463.90	1,712,022,307.27
Ногдол ашгийн өглөг	147,903,712.33	147,903,712.33
Урьдчилж орсон орлого	77,695,300.00	278,809,300.00
Нөөц/өр төлбөр/	502,667,091.00	0.00
Бусад богино хугацаат өр төлбөр	201,810,523.00	0.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,427,953,301.65	8,336,387,222.33
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	1,204,361,562.29	0.00
Бусад урт хугацаат өр төлбөр	898,406.00	898,400.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,205,259,968.29	898,400.00
Өр төлбөрийн нийт дүн	8,633,213,269.94	8,337,285,622.33
Эздийн өмч		
- хувийн	157,362,000.00	157,362,000.00
Халаасны хувьцаа	(531,647,877.83)	(531,647,877.83)
Нэмж төлөгдсөн капитал	3,355,642,713.72	3,355,642,713.72
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,684,074,247.43	1,805,731,926.99
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,814,540,984.30	2,241,324,020.03
Эздийн өмчийн дүн	7,479,972,067.62	7,028,412,782.91
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,113,185,337.56	15,365,698,405.24

10-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН
"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК
 (Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024
Борлуулалтын орлого (цэвэр)	10,368,875,999.52	10,803,400,541.13
Борлуулалтын өртөг	8,802,323,902.95	9,282,439,841.75
Нийт ашиг (алдагдал)	1,566,552,096.57	1,520,960,699.38
Хүүний орлого	24,592.77	253,288.90
Бусад орлого	520,079,742.80	319,757,094.61
Борлуулалт маркетингийн зардал	510,402,649.24	514,275,255.82
Ерөнхий ба удирдлагын зардал	777,896,267.90	1,074,231,670.92
Санхүүгийн зардал	938,741,155.03	807,687,892.01
Бусад зардал	5,623,256.98	12,369,486.88
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(74,026,356.60)	(4,602,747.93)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	1,057,881,008.45
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	(10,945,630.99)	0.00
Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(230,978,884.60)	485,685,037.78
Орлогын татварын зардал	3,307,807.09	59,082,002.04
Татварын дараах ашиг (алдагдал)	(234,286,691.69)	426,603,035.74
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(234,286,691.69)	426,603,035.74
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)	0.00	0.00
Орлогын нийт дүн	(234,286,691.69)	426,603,035.74
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

10-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр
 санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Халавсны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	157,362,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	3,515,568,123.89	2,048,827,675.98	8,545,752,635.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	157,362,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	3,515,568,123.89	2,048,827,675.98	8,545,752,635.76
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	(234,286,691.69)	(234,286,691.69)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00		0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00		0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	(831,493,876.46)	0.00	(831,493,876.46)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	157,362,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	2,684,074,247.43	1,814,540,984.30	7,479,972,067.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	180,000.00	180,000.00
Залруулсан үлдэгдэл	157,362,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	2,684,074,247.43	1,814,720,984.30	7,480,152,067.62
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	426,603,035.74	426,603,035.74
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00		0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	(878,342,320.44)	0.00	(878,342,320.44)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	157,362,000.00	(531,647,877.83)	3,355,642,713.72	1,805,731,926.99	2,241,324,020.04	7,028,412,782.92

10-30 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мө

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

"ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(тегрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	8,471,142,322.59	10,919,804,405.46
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,180,803,313.26	9,985,489,299.90
Татаас, санхүүжилтийн орлого	0.00	44,144,000.00
Бусад мөнгөн орлого	290,339,009.33	890,171,105.56
Мөнгөн зарлагын дүн (-)	8,208,253,365.75	9,735,156,328.66
Ажилчдад төлсөн	863,835,784.19	949,805,332.80
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	313,348,705.03	218,648,953.73
Бараа материал худалдан авахад төлсөн	4,850,883,988.70	5,172,301,625.33
Ашиглалтын зардалд төлсөн	220,507,913.40	230,874,059.62
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	744,718,298.40	1,299,716,601.07
Хүүний төлбөрт төлсөн	69,481,206.54	117,643,923.77
Татварын байгууллагад төлсөн	316,388,987.81	170,277,953.61
Даатгалын төлбөрт төлсөн	96,525.00	2,055,740.00
Бусад мөнгөн зарлага	828,991,956.68	1,573,832,138.73
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	262,888,956.84	1,184,648,076.80
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	24,592.77	253,288.90
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Хүлээн авсан хүүний орлого	24,592.77	253,288.90
Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	144,295,210.00	579,825,783.83
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	144,295,210.00	499,561,548.83
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	2,059,200.00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	0.00	78,205,035.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(144,270,617.23)	(579,572,494.93)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	750,000,000.00	0.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	750,000,000.00	0.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	0.00	0.00
Төрөл бүрийн хандив	0.00	0.00
Ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	801,307,189.91	510,583,964.05
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	801,307,189.91	510,583,964.05
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0.00	0.00
Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(51,307,189.91)	(510,583,964.05)
Валютын ханшийн зөрүү	(4,409,623.83)	19,417.17
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	62,901,525.87	94,511,034.99
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,758,378.78	84,659,904.65
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,659,904.65	179,170,939.64

10-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2025.03.13

№ 002

2025 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө,
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.31.дэх хэсгийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2025 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, зардлын төсвийг мөрдөж ажиллахыг Компанийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ДАРГА



ЗӨВЛӨЛИЙН
Д.БАТХУЯГ



ТУЗ-ийн 2025 оны 6-р сарын 13
ны өдрийн 1 дүгээр тогтоолын 1
дүгээр хавсралт

ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ТӨСӨӨЛӨЛ

	2023	2024	2025
Бэлэн Мөнгө	85	179	289
Авлага	2,879	3,360	3,500
Бараа Материал	4,397	3,814	4,850
Бусад эргэлтийн хөрөнгө	550	589	610
Нийт эргэлтийн хөрөнгө	7,911	7,942	9,249
Цэвэр үндсэн хөрөнгө	7,263	6,483	6,580
Барааны тэмдэг ба хөрөнгө оруулалт	940	940	940
НИЙТ ХӨРӨНГӨ	16,113	15,365	16,769
Богино хугацаат өглөг	7,428	8,337	9,825
Урт хугацаат өглөг	1,205		
Нийт өр төлбөр	8,633	8,337	9,825
Хувьцаа	157	157	157
Халаасны хувьцаа	- 532	- 532	- 532
Нэмж төлөгдсөн капитал	3,356	3,356	3,356
Хөрөнгийн дахин үнэлгээ	2,684	1,806	1,205
Хуримтлагдсан Ашиг	1,815	2,241	2,757
Нийт өөрийн хөрөнгө	7,480	7,028	6,944
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	16,113	15,365	16,769



ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Агуулга	2022	2023	2024	2025
САНХҮҮГИЙН ОРЛОГО, сая төг	10,548	10,889	12,180	13,727
Үр тариа, тэжээл	1,188	2,228	2,340	1,503
Гурил, хивэг	8,809	8,056	7,562	11,119
Бусад	550	606	2,278	1,105
НИЙТ САНХҮҮГИЙН ОРЛОГО	10,548	10,889	12,180	13,727
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	9,194	8,802	9,282	10,302
Үр тариа, тэжээл	1,085	2,280	2,774	976
Гурил, хивэг	8,108	6,460	5,810	8,171
Бусад		62	698	1,155
НИЙТ АШИГ	1,354	2,087	2,898	3,425
Боловсон хүчний холбогдолтой зардал	543	513	514	840
Ерөнхий удирдлагын бусад зардал	973	777	1,074	1,157
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ	1,516	1,289	1,588	1,997
ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖ-НЫ ЦЭВЭР АШИГ	(162)	798	1,310	1,428
Санхүүгийн зардал	579	939	808	879
Ердийн бус орлого зардал	44	91	17	25
ТАТВАРЫН ӨМНӨХ ОРЛОГО	(784)	(231)	485	574
Татварын зардал	6	3	59	57
ТУХАЙН ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАА	(790.3)	(234.3)	426	516



ТХЗ-ийн 2025 оны 6-р сарын 23-ны өдрийн 04 тоот тогтоолын хавсралт №1-2

**1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн охин компани
Алтан Хажир ХХК-ийн 2025 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө**

Мөнгөн зардал	2023	2024	2025
Тариалалт, га	2,465	1,836	770
Улаанбуудай	2,167	1,657	708
Бусад үр тариа	184	129	62
Ногоон тэжээл	114	50	
Га-н ургац, цн			
Улаанбуудай	11	16	20
Бусад үр тариа	9	11	11
Ногоон тэжээл	27	15	15
Нийт ургац, цн	2,813	2,938	1,487
Улаанбуудай	2,383	2,652	1,416
Бусад үр тариа	181	137	71
Ногоон тэжээл	249	150	-

Нийт урннш хийх талбай, га	779.2	1,248	1,592
Нэгжийн өртөг (мөнгөн зардлаар), 1	604.4	686	619
Ажилтнуудын тоо	20	23	18

2. Гурилын үйлдвэрлэлийн 2025 оны төлөвлөгөө

Бүтээгдэхүүн, тн	2023	2024	2025
Тээрэмдэх буудай, тн	4,748	4,307	6,985
1-р ба дээд гурил, тн	3,222	3,162	4,681
2,3-р гурил, тн	359	78	279
Бүхэл үрийн гурил, тн	101	178	162
Хивэг, тн	1,066	889	1,863

Худалдан авч үйлдвэрт нийлүүлсэн, тн	6,831	4,269	7,925
Ажилтаны тоо	35	32	32



Хөвсгөл Алтандуулга ХК-ийн 2025 оны нийт зардлын төсөв

Мөнгөн зардал	Төсөв
Газар тариалангийн зардал	1,959,136,002
Боловсруулах үйлдвэрлэлийн зардал	12,058,750,317
Борлуулалтын зардал	341,288,375
Ерөнхий удирдлагын зардал	1,179,657,332
Санхүүгийн зардал	879,000,000
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	613,065,000
Нийт зардал	17,030,897,025



ТУЗ-ийн 2025 оны 2-р сарын 2-ны өдрийн 2-р тоот тогтоолын Хавсралт 2-1

Хөвсгөл Алтандуулга ХК-ийн газар тариалангийн үйлдвэрлэлийн охин компани Алтан Хажир ХХК-ийн 2025 оны зардлын төсөв

Мөнгөн зардал	Төсөв
Хувьсах зардал бүгд	1,377,457,652
Шатахуун	176,847,670
Цалин, НДШ	81,082,332
Бордоо, ургамал хамгааллын бодис	568,866,081
Үр	110,880,000
Сэлбэг засвар үйлчилгээ, туршилт	427,890,960
Хүнс	11,890,610
Тогтмол зардал бүгд	581,678,349
Цалин, урамшуулал, НДШ	406,335,637
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	6,600,000
Газрын татвар хураамж	8,562,712
Зөвлөх үйлчилгээ	40,000,000
Программ хангамж	2,100,000
цахилгаан холбооны зардал	600,000
Томилолтын зардал	20,000,000
Сургалтын зардал	3,500,000
шатахуун	30,000,000
арга хэмжээний зардал	10,000,000
Талбайн хамгаалалт	17,500,000
Хөрөнгө оруулалт	
зээл, зээлийн хүү	17,000,000
бусад	19,480,000
Зардал бүгд	1,959,136,002



Түүний 2025 оны 4-р сарын 13-ны өдрийн 12-гоот тогтоолын Хавсралт №2-2

Хөвсгөл Алтайн түүхийн ХК-ийн гуримын үйлдвэрийн зардлын 2025 оны төсөв

Мөнгөн зардал	Төсөв
Хувьсах зардал	11,207,700,752
Буудай худалдн авах*	10,105,666,450
Сав баглаа боодол	415,648,145
Ажилтнуудын цалин НДШ	236,611,685
Цахилгаан	259,811,472
Бусад ашиглалтын зардал	348,000
Сэлбэг засвар	115,655,000
Ажилтнуудын хүнс	44,000,000
Шатахуун	29,960,000
Тогтмол зардал	851,049,565
Ажилтнуудын цалин, НДШ	563,213,535
Ашиглалтын Зардал	100,414,800
Тээвэр, шатахуун	1,228,800
Хангамжийн материал	754,900
Хөдөлмөр хамгааллын зардал	17,000,000
Сэлбэг засвар	9,000,000
Элэгдэлийн зардал	116,077,530
Бусад	43,360,000
Нийт мөнгөн зардал	12,058,750,317

Нийт тээрэмдэх буудай, тн

6,985

* Худалдн авч үйлдвэрт нийлүүлсэн, тн

7,925

Ажилтаны тоо

47



2025 оны хөрөнгө оруулалтын төсөв

Нэгж	Төлөвлөсөн хөрөнгө оруулалт	Төсөв
ГҮ	Жижиглэнгийн савлагааны төхөөрөмж	310,565,000
	Поддон хийх	11,500,000
	Сэрээт өргөгчийн баттерей	11,500,000
Даб	Пертен аппарат	179,500,000
Үтр	Силюсны хүлээн авахын цэвэрлэгээний төхөөрөмж	50,000,000
ГТ	Хуучин ГҮ-н дээвэр солих	50,000,000
	НИЙТ	613,065,000.00



ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨВ

№	Хөрөнгө оруулалт зориулалт	ТОО ХЭМЖЭЭ	хөрөнгө оруулалт
1	Үрлэгч	1	402,379,823
2	Нөат Гааль тээвэр		92,368,873
3	Трактор 400MX -ээс дээш OXY Versatile	1	590,000,000
5	8295 их засвар Агромакс ХХК		33,966,240
6	8430 их засвар МСМ ХХК		124,255,184
7	2410 их засвар		74,678,450
8	диск Jeegee VEGA X	2	420,000,000
9	Гүн хавагч Jeegee	2	310,000,000
11	бүл Каток кольчато-шпоровый 12 м-тэй	1	95,000,000
12	бордоо цацагч	1	140,000,000
13	Автомат удирдлагын систем	2	38,000,000
	Дүн		2,320,648,570